

**АВЛИГЫН ЭСРЭГ НҮБ-ЫН КОНВЕНЦИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ХУУЛЬ ТОГТООМЖИЙН  
/ХУУЛЬ ТОГТООХ БАЙГУУЛЛАГУУДАД ЗОРИУЛСАН/ УДИРДАМЖ**

**III. ГЭМТ ХЭРЭГТ ТООЦОХ, ХУУЛЬ САХИУЛАХ**

**30 дугаар зүйл: Яллах, шүүхийн шийдвэр гаргах, шийтгэл ноогдуулах**

1. Оролцогч улс бүр энэхүү конвенцийн дагуу тогтоосон гэмт хэрэгт тухайн гэмт хэргийн ноцтой байдлыг харгалзан шийтгэл ноогдуулна.

2. Оролцогч улс бүр өөрийн төрийн албан тушаалтанд чиг үүргээ гүйцэтгэхэд нь олгосон аливаа дархан эрх буюу шүүхийн харъяаллын давуу эрх болон энэхүү конвенцийн дагуу тогтоосон гэмт хэргийг шаардлагатай бол үр ашигтайгаар мөрдөн байцаах, яллах, ийм хэрэгт шүүхийн шийдвэр гаргах боломжийн хооронд зохих тэнцвэрийг эрх зүйн тогтолцоо болон үндсэн хуулийн зарчимдаа нийцүүлэн тогтоох буюу хадгалахад шаардлагатай байж болох хууль тогтоох болон бусад арга хэмжээг авна.

3. Оролцогч улс бүр энэхүү конвенцийн дагуу тогтоосон гэмт хэрэгт аливаа этгээдийг яллахад хамаарах дотоодын хууль тогтоомжийнх нь дагуу олгосон үзэмжээрээ шийдвэрлэх хууль зүйн эрх мэдлийг тэдгээр гэмт хэргийн хувьд хууль сахиулах арга хэмжээний үр ашгийг аль болох дээшлүүлэхүйцээр бөгөөд ийм гэмт хэргийг үйлдүүлэхгүй байх хэрэгцээг зохих ёсоор харгалзан хэрэгжүүлэх явдлыг хангахыг чармайна.

4. Энэхүү конвенцийн дагуу тогтоосон гэмт хэргийн тохиолдолд оролцогч улс бүр шүүх хуралдаан буюу давж заалдахаас өмнө түр суллах тухай шийдвэртэй холбогдуулан нөхцөл тавихдаа дараагийн эрүүгийн байцаан шийтгэх ажиллагаанд хариуцагчийг байлгах явдлыг хангах хэрэгцээ харгалзан үзсэн байх явдлыг хангахыг эрэлхийлэх талаар зохих арга хэмжээг өөрийн дотоодын хууль тогтоомждоо нийцүүлэн, хариуцагчийн эрхийг зохих ёсоор харгалзан авна.

5. Оролцогч улс бүр гэмт хэрэгт шийтгээгдсэн этгээдийг хугацаанаас нь өмнө суллах буюу тэнсэн суллах боломжийг авч үзэхдээ тухайн гэмт хэргийн ноцтой байдлыг харгалзан үзнэ.

6. Оролцогч улс бүр энэхүү конвенцийн дагуу тогтоосон гэмт хэргийг үйлдсэн гэж яллагдаж буй төрийн албан тушаалтныг зохих эрх бүхий байгууллага нотлогдоогүй бол гэм буруугүйд тооцох зарчмыг хүндлэн үзэж зохих тохиолдолд албан тушаалаас чөлөөлөх, түдгэлзүүлэх буюу өөр албан тушаалд томилж болох журмыг тогтоох асуудлыг эрх зүйн тогтолцооныхоо тулгуур зарчимд нийцсэн хэмжээнд авч үзнэ.

7. Гэмт хэргийн ноцтой байдлаас үзэхэд батлагдаж байгаа тохиолдолд оролцогч улс бүр энэхүү конвенцийн дагуу тогтоосон гэмт хэрэгт яллагдаж буй этгээдийг шүүхийн шийдвэрийн буюу зохих аливаа бусад хэрэгслээр дотоодын хуулиараа тогтоосон хугацаанд дараахь үйл ажиллагаа явуулах эрхийг нь хасах журмыг тогтоох асуудлыг эрх зүйн тогтолцооныхоо тулгуур зарчимд нийцсэн хэмжээнд авч үзнэ:

(a) төрийн алба хаших;

(b) төрийн өмчит буюу төрийн өмчийн оролцоотой аж ахуйн нэгжид алба хаших.

8. Энэ зүйлийн 1 дэх хэсэг эрх бүхий байгууллага төрийн албан хаагчид сахилгын эрх мэдлээ хэрэгжүүлэхийг хөндөхгүй.

9. Энэхүү конвенцийн аль ч заалт энэхүү конвенцийн дагуу тогтоосон гэмт хэргийн болон эрх зүйн холбогдох хамгаалалт буюу тухайн үйлдлийн хууль ёсны байдлыг тодорхойлдог эрх зүйн бусад зарчмын тодорхойлолтыг зөвхөн оролцогч улсын дотоодын хуулиар зохицуулах асуудал байх, түүнчлэн эдгээр гэмт хэргийн тэрхүү хуулийн яллаж, шийтгэх зарчмыг хөндөхгүй.

10. Оролцогч улс бүр энэхүү конвенцийн дагуу тогтоосон гэмт хэрэгт яллагдаж буй этгээдийг нийгэмд дахин нэгдэн орохыг дэмжихийг чармайна.

## I. Ерөнхий тойм

378. 30 дугаар зүйл авлигатай тэмцэх үйл ажиллагааны чухал асуудлуудыг хөнддөг ба хуулийн этгээдийн хариуцлага (26 дугаар зүйл), гэмт хэргийн улмаас олсон эд хөрөнгийг битүүмжлэх, түр хураах, хураах (31 дүгээр зүйл), хөрөнгө буцаан олгох (V бүлэг) зэрэгтэй холбоотой заалтуудаар нэмж, тодруулж өгдөг.

Энэ зүйл нь оролцогч улс бүр Конвенцийн дагуу тогтоосон гэмт хэрэгт зохих шийтгэл ногдуулах, хугацаанаас өмнө суллах буюу тэнсэн суллах асуудлыг шийдвэрлэхдээ гэмт хэргийн ноцтой байдлыг анхаарахыг шаарддаг. Түүнчлэн оролцогч улс бүр эдгээр гэмт хэрэг үйлдэгдэхээс урьдчилан сэргийлэхийн тулд дотоодын хууль тогтоомжид заасан үзэмжээрээ шийдвэрлэх бүрэн эрхийг хангахыг шаарддаг. 30 дугаар зүйлийн дагуу оролцогч улс бүр төрийн албан тушаалтны ашиглаж буй дархан эрх болон авлигын гэмт хэрэгтэй нь холбоотой мөрдөн шалгах, яллах боломж хоорондын зохих тэнцвэрийг хангах ёстой.

381. 30 дугаар зүйлд заавал хэрэгжүүлэх болон заавал хэрэгжүүлэх албагүй дор дурдсан заалтууд багтаж байгаа болно.

### i) Заавал хэрэгжүүлэх заалтууд

382. Авлигын эсрэг Конвенци оролцогч улс бүр Конвенцийн дагуу тогтоосон аливаа гэмт хэрэгт тухайн гэмт хэргийн ноцтой байдлыг харгалзан шийтгэл ногдуулахыг шаарддаг(1 дэх хэсэг).

383. Конвенцийн дагуу тогтоосон гэмт хэрэгт ногдуулах шийтгэлийн хатуу чанга байдлыг оролцогч улс бүр өөрөө тодорхойлно. Гэхдээ эдгээр гэмт хэргийн ноцтой байдлыг харгалзан үзэх ёстой. Үүнтэй холбогдуулан 30 дугаар зүйлийн 9 дэх хэсэгт оролцогч улсын дотоодын хууль тогтоомжоор зохицуулах асуудлыг тогтоосон болно. Оролцогч улс бүр яллах үйл ажиллагааны явцад шүүхийн шийдвэр гаргах болон засан хүмүүжүүлэх арга хэмжээг хэрэгжүүлэх, засан хүмүүжүүлэх шийдвэр гаргах явцдаа гэмт хэргийн ноцтой шинж чанар болон түүнийг үйлдэхээс урьдчилан сэргийлэх шаардлагыг харгалзан үзэхийг эрмэлзэх ёстой<sup>48</sup><sup>1</sup>. Түүнчлэн эрх бүхий байгууллагууд төрийн албан хаагчид сахилгын шийтгэл ногдуулахад энэхүү заалт ямар нэгэн хохирол учруулахгүйг конвенцид тайлбарласан байдаг (30 дугаар зүйлийн 8 дахь хэсэг).

385. Шударга ёсны болон тогтоон барих зарчмуудын дагуу яллагдсан гэмт хэрэгтнүүдэд чанга дэглэм хэрэглэхийг Конвенци хөхүүлэн дэмждэг. 30 дугаар зүйлийн 5 дахь хэсэг нь оролцогч улс бүр конвенцийн дагуу тогтоосон гэмт хэрэгт ял шийтгэгдсэн этгээдийг хугацаанаас нь өмнө суллах буюу тэнсэн суллах боломжийг авч үзэхдээ тухайн гэмт хэргийн ноцтой байдлыг харгалзан үзэхийг шаарддаг<sup>49</sup><sup>2</sup>.

386. 2 дахь хэсгийн дагуу оролцогч улс бүр төрийн албан тушаалтанд чиг үүргээ гүйцэтгэхэд нь олгосон аливаа дархан эрх буюу шүүхийн харъяаллын давуу эрх болон энэхүү конвенциор тогтоосон гэмт хэргийг шаардлагатай бол үр ашигтайгаар мөрдөн байцаах, яллах, шүүхийн шийдвэр гаргах боломжийн хооронд зохих тэнцвэрийг өөрийн эрх зүйн тогтолцоо болон Үндсэн хуулийн зарчимдаа нийцүүлэн тогтоох буюу хангах ёстой.

387. Авлигад автсан төрийн албан тушаалтан хариуцлагаас зугатах, ноцтой гэмт хэргийг мөрдөн шалгах буюу яллахаас зайлсхийх боломж эдлэх нь авлигатай тэмцэх стратегийн хуульт ёс, шударга ёсонд итгэх нийгмийн итгэл, хувийн хэвшлийн үйл ажиллагаа, олон улсын хамтын ажиллагаанд үлэмж хохирол учруулна. 30 дугаар

---

<sup>1</sup> Хэрэв конвенцийн оролцогч улсын зохион байгуулалттай гэмт хэрэгтэй тэмцэх талаарх үндэсний хууль тогтоомжийн төсөл боловсруулагчид энэхүү конвенцид хамрагдахгүй байгаа авлигын гэмт хэрэгт хэрэглэхийг хүсвэл эдгээр гэмт хэргүүдийг “ноцтой гэмт хэрэг”-т тооцуулахын тулд хорих ялын дээд хэмжээг дөрвөн жилээс доошгүй байхаар тусгах шаардлагатай.

<sup>2</sup> Шийтгэгдсэн гэмт хэрэгтнүүдийг хугацаанаас нь өмнө суллах буюу тэнсэн суллах практик олон эрх зүйн тогтолцоонд байдаг. Тэгэхдээ үүнийг бүрэн хориглосон туршлага ч мөн байдаг. Хэрэв өөрийн нь тогтолцоонд энэ талаар тусгаагүй бол Авлигын эсрэг конвенци ийм практик хэрэгжүүлэхийг санал болгодоггүй. Тэгэхдээ гэмт хэргийн ноцтой байдлыг харгалзан үзэж хугацаанаас нь өмнө суллах буюу тэнсэн суллах боломжтой гэж үзэж буй оролцогч улсад энэхүү суллах эрх олгож буй хамгийн доод хугацааг нэмэгдүүлэх боломжийг авч үзэх талаар конвенци зөвлөдөг. Үүний тулд дотоодын хууль тогтоомж болон бусад конвенцид заасан аливаа хүндрүүлэх нөхцөл байдлыг анхаарч үзэхийг зөвлөдөг.

зүйлийн 2 дэх хэсгийн зорилго нь ийм тохиолдлуудыг таслан зогсоох буюу бий болохоос урьдчилан сэргийлэхэд оршдог.

390. Авлигад автсан зарим төрийн албан тушаалтнуудын хэрэгжүүлж буй хууль бус ажиллагаа багагүй ашиг авчирч болно. Иймд яллагдагчид шүүх хуралдаан болтол, эсхүл давж заалдах өргөдөл болон эсэргүүцлийн дагуу шийдвэр гарах хүртэл цагдан хоригдохоос зайлсхийхийн тулд шүүхэд барьцаа төлөх их хэмжээний хөрөнгөтэй байж болно. Үүний дүнд барьцааны үйлчлэл суларч байна. Иймээс үндэсний хууль тогтоомжийн төсөл боловсруулагчид энэ тохиолдолд хуулийн хэрэглээний үр ашиг буурах аюулыг харгалзах ёстой. 30 дугаар зүйлийн 4 дэх хэсэгт шүүх хуралдаан болтол, эсхүл давж заалдах өргөдөл болон эсэргүүцлийн дагуу шийдвэр гарах хүртэл санамсар, болгоомжгүй суллахын аюулыг зааж, яллагдагч оргон зайлахгүйн тулд түүний эрхийг зохих ёсоор харгалзан улс бүр өөрийн хууль тогтоомжийн дагуу зохих арга хэмжээг авах хэрэгтэй.